

## **Агуулга**

- 1. Танилцуулга**
- 2. Гарын авлагын үндэслэл**
- 3. Нийцлийн аудитыг зохион байгуулах ба тайлагнах онцлог шинж**
- 4. Бусад аудитын стандартуудтай уялдах харилцаа холбоо**

## **Товчилсон үгс**

### **АДБ –АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГА**

### **АДБОУС – АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ**

#### **1 Танилцуулга**

1. Нийцлийн аудит нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаа холбогдох хууль эрх зүй, зохицуулалт, дүрэм журмын дагуу хэрэгжиж буй эсэхэд аудит хийх АДБ-ын чиг үүргийг зохицуулна. Үүнд шалгагдагч байгууллагын сайн засаглалыг хэрэгжүүлж байгаа болон хариуцлага хүлээх чадварын түвшинг тайлагнах багтана. Тодруулбал, эдгээр элементүүдэд тухайн шалгагдагч байгууллага дүрэм журам, хууль эрх зүй, зохицуулалтын бодлого, тогтоосон хэм хэмжээ болон гэрээ эсвэл санхүүжилтийн хэлэлцээрийн нөхцөл г.м зөвшилцсөн нөхцлүүдийг ямар түвшинд даган мөрдөж байгаад аудит хийх багтах юм. АДБ-уудын гүйцэтгэж буй нийцлийн аудит нь өргөн хүрээний шалгах асуудлуудыг хамрах ба олон улсын түвшинд харилцан адилгүй байж болно.
2. Тодорхой нэг нийцлийн аудитын зорилго, хамрах хүрээ, мөн чанар нь АДБ-ын бүрэн эрх, Үндсэн хуульд заасан чиг үүрэг мөн түүнчлэн шалгагдагч байгууллагатай холбоотой хууль тогтоомж зэрэг хэд хэдэн зүйлсээс хамаардаг. Ерөнхийдөө нийцлийн аудитын зорилго нь шалгагдагч байгууллага тодорхой багц шалгууруудыг хангаж буй эсэх талаар холбогдох байгууллагуудад тайлагнах боломжийг АДБ-д олгох юм. Эдгээр шалгууруудыг холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, хууль, тогтоомж, парламентын шийдвэрүүд, гэрээ эсвэл хэлэлцээрийн нөхцлүүдээс тодорхойлж болох ба эсвэл аудиторын тохиромжтой гэж үзсэн бусад шалгуурууд байж болно.
3. Нийцлийн аудитын гарын авлага Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт (АДБОУС)-ын үзэл баримтлалын дөрөвдүгээр түвшинд

(Аудитын гарын авлага) хамаарах ба суурь зарчмууд нэгдүгээр түвшинг, АДБ-уудын дүрмүүд хоёрдугаар түвшинг, аудитын үндсэн зарчмууд гуравдугаар түвшинг (ИНТОСАИ-н аудитын стандартуудыг багтаан) тус тус бүрдүүлнэ.

4. Санхүүгийн тайлангийн аудиттай хамт гүйцэтгэх нийцлийн аудитын тухайд ИНТОСАИ-н Санхүүгийн аудитын гарын авлага (АДБОУС1000-2999)-д Нийцлийн аудитын гарын авлага нь нэмэлт материал болно.
5. Төрийн салбарын бүтэц болон АДБ-ын бүрэн эрхээс хамааран Нийцлийн аудитын гарын авлага нь төв, бүс мөн түүнчлэн орон нутгийн гэсэн засаглалын бүхий л түвшинд хийх нийцлийн аудитыг хамарна. Энэхүү гарын авлагыг хамтын ажиллагааны хэлэлцээрээр эсвэл төсвөөс зээл, тусламж хүлээн авах зэргээр төрийн өмч болон үйлчилгээг удирдан зохион байгуулахад оролцож буй хувийн аж ахуйн нэгжүүдэд аудит хийхэд ашиглаж болно.
6. Нийцлийн аудитын гарын авлага нь хоёр гол үзэл баримтлалаар боловсруулагдсан. Үүнд:
  - АДБОУС 4100 нь Санхүүгийн тайлангийн аудитаас ангид гүйцэтгэх нийцлийн аудит жишээлбэл, бие даасан аудит эсвэл гүйцэтгэлийн аудиттай холбоотой нийцлийг аудитыг авч үзнэ
  - АДБОУС 4200 нь санхүүгийн тайлангийн аудиттай хамааралтай нийцлийн аудитыг авч үзнэ.

Эдгээр 2 АДБОУС-ууд тогтвортой, бие даасан баримт бичгүүд юм. Нийцлийн аудитын төлөвлөлт болон гүйцэтгэлтэй холбоотой ихэнх материалууд хоорондоо ойролцоо эсвэл бүр ижил байж болно. Гэсэн хэдий ч зайлшгүй ялгах шаардлагатай тохиолдолд тусгай зориулалтаар удирдамжийг оруулж өгсөн.

## **2 Гарын авлагын үндэслэл**

7. ИНТОСАИ-н Нийцлийн аудитын гарын авлага нь ИНТОСАИ-н Аудитын стандартуудыг АДБ-уудад, ялангуяа хууль дүрмийн нийцлийг тайлагнах үйл ажиллагаандаа, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулагдсан. АДБОУС-уудын нэгэн адилаар энэхүү удирдамжийг тухайн АДБ-ын хувьд заавал нэвтрүүлэх шаардлагагүй бөгөөд тухайн орныхоо нөхцөлд, бүрэн эрхийнхээ хүрээнд тохируулан аль түвшинд дагаж мөрдөхөө АДБ-ууд өөрсдөө шүүн тунгаах хэрэгтэй.

8. Гарын авлага нь Ерөнхий аудиторын тогтолцоотой болон Тооцооны шүүхийн тогтолцоотой АДБ-ууд дахь нийцлийн аудитуудыг хамрахыг зорьсон гэхдээ шүүхийн тогтолцоотой АДБ-ууд дахь нийцлийн аудитын шүүн таслах үйл ажиллагаатай холбоотой онцлогуудыг хамраагүй болно.

### **3 Нийцлийн аудитыг зохион байгуулах болон тайлагнах онцлог**

9. АДБ-ууд өөрсдийн Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрх, чиг үүргийнхээ хүрээнд хамгийг үр ашигтай гэж үзсэн аргаар аудитыг зохион байгуулдаг. Бодит байдал дээр энэ нь нийцлийн аудитын зохион байгуулалт, тайлагнал дахь олон улсын онцлог байдлуудыг өндөр түвшинд гаргаж ирдэг. Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн эсвэлгүйцэтгэлийн аудитуудын нэг хэсэг болгон хийж болно. Мөн нийцлийн аудитыг бие даасан аудит болгон, жишээлбэл, хууль тогтоох байгууллага эсвэл АДБ үйл ажиллагаагаа тайлагнадаг бусад байгууллагын хүсэлтээр эсвэл АДБ-ын өөрийн санаачлагаар гүйцэтгэж болно.

10. Зарим АДБ-ууд өөрсдийн бүрэн эрх эсвэл бусад зүйлээр тогтоосон нийцлийн аудитын тусгай үүрэг даалгавар, чиг үүрэгтэй байж болно. Эдгээр үүрэг даалгавар дараах зүйлсийг багтаана. Үүнд:

А) Тооцооны шүүхийн зохион байгуулалттай АДБ-ын шүүх чиг үүрэг,

Б) Сэжиглэгдсэн залилан болон авилгатай холбоотой үйл ажиллагаа

В) Хувь хүнд шийтгэл ногдуулах эсвэл хууль хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудад тайлагнах зорилгоор хууль бус үйлдэл эсвэл бусад сахилгын зөрчилд хийх шалгалт

Г) Яамдуудаас парламентэд өргөн барьсан мэдээллийн иж бүрэн болон үнэн зөв байдалд хийх үнэлгээ

11. Нийцлийн аудитын тайлан янз бүрийн хэлбэртэй байж болно. Үүнд:

А) Нийцлийн аудитын бие даасан тайлан: Тайлангийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагаас шалтгаалан товч эсвэл дэлгэрэнгүй гэсэн хэлбэртэй байж болно.

Б) Нийцлийн талаарх санал дүгнэлт: Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын тайлан эсвэл тусдаа тайланд тусгагдсан байж болно.

В) Бусад аудит хийгдэх үеэр аудиторуудын анхааралд өртсөн үйл ажиллагаа буюу ажил гүйлгээнүүд нь хууль тогтоомжуудтай нийцэж буй эсэхийг илэрхийлсэн санал дүгнэлт

Г) Зөрчлийн тодорхой тохиолдлын талаарх тайлан

а) Аудитын явцад аудиторуудын анхаарлыг татах зөрчлийн тохиолдол байгаагүй талаар илэрхийлсэн тайлан

12. Дээрх хувилбаруудын талаар Нийцлийн аудитын гарын авлагад шаардлагатай үед тайлангийн жишээтэй хамт тайлбарласан болно.

#### **4 Бусад аудитын стандартуудтай уялдах харилцаа холбоо**

13. Нийцлийн аудитын авлага нь ИНТОСАИ-н Аудитын үндсэн зарчмууд болон ИНТОСАИ-тай хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг НБОУХ, дотоод аудиторуудын институт (IIA) зэрэг бусад стандарт боловсруулдаг байгуулагуудаас гаргасан стандартуудад үндэслэгдэн боловсруулагдсан.

14. НБОУХ-ны Аудит, баталгаажуулалтын олон улсын стандартын зөвлөлөөс /АБОУСЗ/-өөс гаргасан Баталгаажуулах ажлын олон улсын үзэл баримтлал нь шалгах асуудлыг шалгууруудын дагуу хэмжиж эсвэл үнэлснээс гарсан үр дүнгийн талаар хариуцагч талаас гадна тайлангийн зорилтот хэрэглэгчдийн итгэл үнэмшлийн түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн дүгнэлтийг баталгаажуулагч илэрхийлэх ажлыг анхаарч үздэг. Энэхүү үзэл баримтлалын хүрээнд Аудитын олон улсын стандарт (АОУС)-ыг санхүүгийн тайланг баталгаажуулах үйл ажиллагааг ашиглана. Баталгаажуулах ажлын олон улсын стандарт (БАОУС)-ыг санхүүгийн тайлангаас бусад шалгах асуудлуудын мэдээлэлд баталгаажуулалт гаргах үйл ажиллагаанд ашигладаг.

15. АДБ-ууд Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрх, гүйцэтгэх чиг үүргийнхээ хүрээнд нийцлийн аудитыг гүйцэтгэдэг. АДБ-ууд төрийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэх болон төрийн салбарын удирдлагыг сайжруулахад хувь нэмрээ оруулах чухал үүрэгтэй. Хэдийгээр Аудитын олон улсын болон

Баталгаажуулах ажлын олон улсын стандартууд төрийн аудиторуудын үйл ажиллагаатай холбогдох авч нийцлийн аудитын хамрах хүрээ, тайлагнах чиг үүрэг нь дээрх стандартуудад дурдсанаас илүү өргөн хүрээтэй юм.

16. Дотоод аудиторуудын институтээс гаргасан Дотоод аудитын Мэргэжлийн практикийн олон улсын стандартад дотоод аудитыг байгууллагын үйл ажиллагаанд үнэ цэнэ нэмж, сайжруулах зорилго бүхий хараат бус, бодит баталгаажуулалт өгөх ба зөвлөх үйл ажиллагаа гэж тодорхойлсон байдаг. Дотоод аудитын үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, зохицуулалт болон гэрээний нөхцөл, байдлуудтай тухайн байгууллагын засаглал, үйл ажиллагаа ба мэдээллийн систем нийцэж буй эсэх зэрэг хяналтын үр өгөөж, хангалттай байдал ба эрсдлийг үнэлнэ. Хэрэв АДБ-ын нийцлийн аудитын үйл ажиллагаа дотоод аудиторуудад түшиглэх болдотоод аудиторууд Дотоод аудиторуудын институтын стандартуудыг ямар түвшинд ашигласныг АДБ бас анхаарч үзнэ.